



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/533

Арвайхээр сум

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд
оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 сарын 17-ны өдрийн “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах тухай 183 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.1.1.1, 1.1.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцоход зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад заасан 14,159,680 (арван дөрвөн сая нэг зуун тавин есөн мянга зургаан зуун наян) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 1065

D:My Doc. Zahirambj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 30-ны өдрийн 1153 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬД ОРОЛЦОХОД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга,
цагдаагийн хурандаа)

Д.Өсөх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх
хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын дарга)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын
дарга)

Ц.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Л.Пүрэвлхам (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний
агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, урлагийн
хэлтсийн дарга)

С.Шийлэгцэрэн (аймгийн Засаг даргын эрхлэх
хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын Захиргаа
удирдлагын хэлтсийн дарга)

Н.Баярцэнгэл (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний
агентлаг Соёл, урлагийн газрын урлаг уран бүтээлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Х.Бэлэгдэмбэрэл (аймгийн Засаг даргын эрхлэх
хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын ахлах
мэргэжилтэн)

А.Бүрэндэлгэр (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний
агентлаг Соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн)

Б.Ууганбаяр (аймгийн Худалдаа аж үйлдвэрийн
танхимын дарга)

Н.Буянбадрах (“Барт хүрээ” төрийн бус байгууллагын
гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга: А.Дэлгэрнасан (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний
агентлаг Соёл, урлагийн газрын мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2023 оны 30 дугаар
сарын 30-ны өдрийн 1531 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**“НҮҮДЭЛЧИН” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬД
ОРОЛЦОХОД ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр, төрөл	Мөнгөн дүн
1	Үндсэн хөрөнгө худалдан авсан	5,000,000
1.1	5 ханатай эрээн модон гэр	5,000,000
2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	1,352,000
2.1	Автобус, ачааны машины хөлс, үлдэгдэл	1,000,000
2.2	Портер түрээс	300,000
2.3	Цэвэрлэгээ үйлчилгээ	52,000
3	Кемп, гэр буудлын түрээс	924,000
3.1	Гэрийн түрээсний үлдэгдэл	924,000
4	Хүнс, бараа материал худалдан авсан	6,883,680
4.1	5 кг өрөм үнэ	65,000
4.2	20 кг ааруулын үнэ	500,000
4.3	20 кг бяслагийн үнэ	500,000
4.4	840 л айргийн үнэ	3,360,000
4.5	42 хүн, 4 өдрийн хоолны материалын үнэ	1,670,300
4.6	Сүүн чихрийн үнэ	190,000
4.7	Атлас, ямбуу, бэхний үнэ	512,380
4.8	Гэр болон асар барихад хэрэглэгдэх барилгын материалын үнэ	86,000
Нийт зардал		14,159,680